

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Хариултын хуудасны заавартай сайтар танилцана уу.

- Энэхүү хэсэг нь 40 сонгох даалгавар, нийт 80 оноотой.
- Даалгавар бүр 5 сонгох хариулттай бөгөөд зөвхөн нэгийг сонгоорой.
- Сонгосон хариултаа хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй.
- Эхийг анхааралтай уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.
- 1-13 дугаар даалгаврыг эхийн утга санаатай холбон ажиллаарай.

Сайхан

(эсээ)

Баясал, бишрэлийг төрүүлэн, сэтгэлийн цог залиг бадрааж чадах төгс төгөлдөр бүтэж бүрэлдсэн юм ертөнцөд ховор. Нэг шинж нь байвч нөгөө нь үгүй. Нэг хэсэг шинж бүрдсэн атал ганц гол нь үгүй байх жишээтэй. Ер нэгэн бие, нэгэн үзэгдэлд бүрнээр бүрэлдэх нь ховроос ховор агаад тэрхүү олон шинжийг өөртөө бүрэн дүүрэн цогцлуулсан үлэмж төгөлдрийг сайхан хэмээнэ.

Сайхны нэг гол шинж бол ариун. Ариунгүй сайхан гэж үгүй. Хорвоо ертөнцийн хосгүй гайхамшиг болсон уул ус, нар сарны гэрэл гэгээ цөм ариун тансаг. Сайхан бол хэмжээлшгүй. Зун цагийн үүрийн шаргал туяа, эсвэл гоо үзэсгэлэнгийн манлай болсон бүсгүйн хэр сайхныг хэн ч хэмжээлж чадахгүй. Сайхныг нь хэмжих хэмжүүр үгүй. Сайхан бол эд эс, үе гишүүдийн найрсан зохицсон зохирол. Нэг ч навч нахиа, дэлбээ дохиур бусдаасаа товойн үзэгдэх гэж үгүй, цөм өөр хоорондоо найрсан дээд зохирлыг бүрдүүлдэг.

Сайхан гэдэг бол олон тоо бус ганц тоо. Ганц учраас давтагдашгүй. Давтагдашгүй учраас аливаа нэгэнтэй зүйрлэх зүйрлэлээс ангид. Гагц ганцаар төрж, ганцаар оршин байдаг ижилгүй ертөнц.

Сайхан бол зүй тогтол бус, тохиолдол. Хэний ч, ямар ч хүсэл зарлигаас үл хамааран төрөх цагтаа л төрдөг хувь тавилан, буян заяа. Зориудаар түүнийг хэн ч бүтээж чадахгүй. Үлэмж дээд сайхан гэдэг бол тэнгэрийн хишиг. Санаандгүй явтал өмнүүр тань нумлан татдаг солонго.

Сайхан бол орчлон ертөнцийн нэгэн тайлагдашгүй нууц. Нууцыг тайлах гэж оролдох нь усны мандал дээрх хөөсийг барьж авах гэсэнтэй адил.

Сайхны мөн чанарт орших нэгэн шинж бол гэгээн гуниг. Сайхан бүсгүйн тунгалаг нүд, сайхан цэцгийн дэлбээ, тэргэл сарны гэрэлд сэтгэлийн үзүүрт тэмтрэгдэх төдий юм. Энэ нь сайханд чимэг нэмж байдаг гэгээн гуниг. Сайхан нэг талаас цаанаасаа төрсөн буян заяа төдийгүй, нөгөө талаас түүнийг бишрэн шагших сэтгэлийн хүчинд улам жавхаажиж байдаг.

Сайхныг ухаанаар бус сэтгэлээр мэдэрдэг. Сайхан байгаагийн учир шалтгааныг олох гэж ухаанаар төнхөх нь гэрэлтэн туяарах биндэрьяаны өнгөнд санаархан хагалахтай адил. Эд эс, үе гишүүнээр нь задалмагц сайхан гэгч устаж үгүй болдог. Сайхан бүхэн эмзэг турьхан, энхрий ялдам. Өчүүхэн төдий гутаг суухад алга урвуулахын зуурт зүүд мэт одох нь ч байдаг.

Сайхны бэлгэ тэмдэг бол дөрвөлжин бус, гурвалжин бус, олон өнцөгт бус, зөвхөн тойрог. Тэргэл саран мэт дүгрэг тойрог. Тойрогт дутуу юм байдаггүй. Дутуу юмгүй, илүү юмгүй бүхэн төгс төгөлдөр. Төгс төгөлдөр гэгч сайхан.

Д.Батбаяр

1. Эхэд буй үгсийг утгатай нь зөв тохируулаарай.

- | | |
|--------------|-----------------------------------|
| 1. дохиур | a. сэтгэл шаналал |
| 2. гутаг | b. дугариг дугуй дүрс |
| 3. дүгрэг | c. тунгалаг, хатуу эрдэнийн чулуу |
| 4. биндэрьяа | d. цэцгийн тоос агуулах эрхтэн |
| 5. зохирол | e. нийцэл бүрдэл |

A. 1d, 2a, 3b, 4c, 5e

B. 1d, 2a, 3e, 4b, 5c

C. 1a, 2b, 3e, 4c, 5d

D. 1c, 2e, 3b, 4a, 5d

E. 1d, 2a, 3b, 4e, 5c



2. Эсээний хөтөч санаа аль вэ?

- A. Хэний ч, ямар ч хүсэл зарлигаас үл хамааран төрөх цагтаа л төрдөг хувь тавилан, буян заяа.
- B. Олон шинжийг өөртөө бүрэн дүүрэн цогцлуулсан үлэмж төгөлдрийг сайхан хэмээнэ.
- C. Сайхны бэлгэ тэмдэг бол дөрвөлжин бус, гурвалжин бус, олон өнцөгт бус, зөвхөн тойрог.
- D. Хорвоо ертөнцийн хосгүй гайхамшиг болсон уул ус, нар сарны гэрэл гэгээ цөм ариун тансаг.
- E. Ганц учраас давтагдашгүй. Давтагдашгүй учраас аливаа нэгэнтэй зүйрлэх зүйрлэлээс ангид.

3. Зохиогч “Сайхны нэг гол шинж ариун” гэсэн бол “Сайхны мөн чанар”-т орших нөгөө шинжийг юу гэсэн бэ?

- A. гэгээн гуниг
- B. буян заяа
- C. эмзэг турьхан
- D. үлэмж төгөлдөр
- E. тэнгэрийн хишиг

4. Зохиогчийн үзэл бодол бүхий өгүүлбэрийг сонгоорой. Ингэхдээ дараах тодорхойлолтыг ашиглаарай.

Мэдрэмж	Дүгнэлт	Үзэл бодол
Таван мэдрэхүйд мэдрэгдсэн зүйл	Хурааж нэгтгэсэн баталгаа	Санаанд илрэх санал

- A. Сайхан бүхэн эмзэг турьхан, энхрий ялдам.
- B. Зориудаар түүнийг хэн ч бүтээж чадахгүй.
- C. Үлэмж дээд сайхан гэдэг бол тэнгэрийн хишиг.
- D. Сайхныг ухаанаар бус сэтгэлээр мэдэрдэг.
- E. Сайхан бол орчлон ертөнцийн тайлагдашгүй нууц.

5. “Сайхан нь ер нэгэн бие нэгэн үзэгдэлд бүрнээр бүрэлдэх нь ховроос ховор” гэсний учир юу вэ?

- A. Нэг шинж нь байвч нөгөө нь үгүй байдаг учраас
- B. Сайхан бол төрөх цагтаа л төрдөг хувь тавилан учраас
- C. Нэг хэсэг шинж бүрдсэн атал ганц гол нь үгүй байдаг учраас
- D. Ганцаар төрж, ганцаар оршин байдаг ертөнц учраас
- E. Давтагдашгүй бөгөөд аливаа нэгэнтэй зүйрлэх зүйрлэлээс ангид учраас

6. “Сайхан бол ариун, хэмжээлшгүй, давтагдашгүй, буян заяа, тайлагдашгүй, гэгээн гуниг, эмзэг турьхан” гэсэн санаануудыг аль үг нэгтгэн дүгнэж байна вэ?

- A. зүй тогтол
- B. бэлгэ тэмдэг
- C. хувь тавилан
- D. гоо үзэсгэлэн
- E. төгс төгөлдөр

7. “Сайхан” гэгчийг хэрхэн мэдэж, мэдэрч болох вэ?

- A. үе гишүүдээр нь задалж
- B. ухаанаар төнхөж
- C. сэтгэлийн хүчээр
- D. гэгээн гунигаар
- E. дутуу юмгүй шинжээр нь

8. Эсээнд ямар асуудлыг дэвшүүлсэн байна вэ?

- A. Сайхан хэмээх ойлголтын тухай
- B. Сайхныг танин мэдэх тухай
- C. Сайхан бүхэн эмзэг байдаг тухай
- D. Сайхан бүхэн давтагдашгүй байдаг тухай
- E. Сайхан нь хувь тавилангаар бий болдог тухай



9. Гол санааг илэрхийлэх өгүүлбэр аль вэ?

- A. Төгс төгөлдөр бүтэж бүрэлдсэн юм ертөнцөд ховор.
- B. Сайхан бүхэн эмзэг турьхан, энхрий ялдам байдаг.
- C. Сайхныг ухаанаар бус сэтгэлээр мэдэрдэг.
- D. Дутуу юмгүй, илүү юмгүй бүхэн төгс төгөлдөр байдаг.
- E. Сайхан бол төрөх цагтаа л төрдөг хувь тавилан.

10. Аливаа зүйлийн мөн чанарыг аажмаар өсгөн дүрсэлж, хүч нэмэн ахиулсан ахиулал бүхий хэсгийг олоорой.

- A. Гагц ганцаар төрж, ганцаар оршин байдаг ижилгүй ертөнц. Сайхан бол зүй тогтол бус тохиолдол.
- B. Сайхан гэдэг бол олон тоо бус ганц тоо. Ганц учраас давтагдашгүй. Давтагдашгүй учраас аливаа нэгэнтэй зүйрлэх зүйрлэлээс ангид.
- C. Үлэмж дээд сайхан гэдэг бол тэнгэрийн хишиг. Санаандгүй явтал өмнүүр тань нумлан татдаг солонго.
- D. Сайхан бол зүй тогтол бус, тохиолдол. Хэний ч, ямар ч хүсэл зарлигаас үл хамааран төрөх цагтаа л төрдөг хувь тавилан, буян заяа.
- E. Сайхан бүсгүйн тунгалаг нүд тэргэл сарны гэрэлд сэтгэлийн үзүүрт тэмтрэгдэх төдий юм. Энэ нь сайханд чимэг нэмж байдаг гэгээн гуниг.

11. “Сайхан бол орчлон ертөнцийн нэгэн тайлагдашгүй нууц” өгүүлбэрийг салаалан хувиргасан нь аль вэ?

- A. Сайхан бол хорвоо дэлхийн нэгэн тайлагдашгүй нууц.
- B. Сайхан бол энэ орчлон ертөнцийн нэгэн тайлагдашгүй нууц.
- C. Сайхан бол орчлон ертөнцийн тайлагдашгүй нууц.
- D. Сайхан бол орчлон ертөнцийн тайлагдашгүй нэгэн нууц.
- E. Сайхан бол орчлон ертөнцийн нэгэн тайлагдашгүй онцгой нууц.

12. “Нууцыг тайлах гэж оролдох нь усны **мандал дээрх** хөөсийг барьж авах гэсэнтэй адил” өгүүлбэрийн “мандал дээрх” гэсэн үг аль үгтэй холбогдож, ямар утгаар орсон бэ?

- A. “хөөсийг” гэсэн үгтэй холбогдож, харьяаны утгаар
- B. “хөөсийг” гэсэн үгтэй холбогдож, цагийн утгаар
- C. “хөөсийг” гэсэн үгтэй холбогдож, орны утгаар
- D. “барьж авах” гэсэн үгтэй холбогдож, харьяаны утгаар
- E. “барьж авах” гэсэн үгтэй холбогдож, орны утгаар

13. “Сайхны мөн чанарт орших нэгэн шинж бол гэгээн гуниг” өгүүлбэрийг зөв тодорхойлсон нь аль вэ?

- A. Тодотгол гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
- B. Шууд бус тусагдахуун гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
- C. Шууд тусагдахуун гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
- D. Байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
- E. Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр

14. “Эд эс, үе гишүүнээр нь задал**магц** сайхан гэгч үгүй болдог” өгүүлбэрийг шалтгааны утгатай болгоход аль нөхцөл тохирох вэ?

- A. -аад B. -саар C. -вч D. -хлаар E. -ж

15. “Орж ирсэн гурвын **хоёрыг нь** урьд өмнө огт үзээгүй хүмүүс байв” өгүүлбэрийн “**хоёрыг нь**” хэмээх үг ямар үгсийн аймгийн үүргээр орсон бэ?

- A. тэмдэг нэрийн B. жинхэнэ нэрийн C. орон цагийн нэрийн
- D. төлөөний үгийн E. тооны нэрийн



16. Идэвхгүй язгуураас бүтсэн үгийг олоорой.

- A. хөмөл **таана** B. цавуугаар **наана** C. оньсого **таана**
D. замын **наана** E. туулай **хөөнө**

17. “гутал” хэмээх үгийг нутгийн аялгуутай нь зөв харгалзуулсныг олоорой.

- a. годоно 1. ойрад
b. госн 2. буриад
c. готол 3. баяд
- A. a1, b3, c2 B. a2, b1, c3 C. a3, b1, c2
D. a2, b3, c1 E. a3, b2, c1

18. Бүлэг үгийн бүтээврийн үүргийг ажиглаад, дарааллаараа тохирохыг сонгоорой.

<i>алтан</i>	<i>цомбон</i>	<i>гахайн</i>
<i>мөнгөн</i>	<i>шовон</i>	<i>хангайн</i>
<i>элсэн</i>	<i>оцон</i>	<i>ойн</i>
.....		

- A. модон, шувтан, зайн B. модон, зайн, шувтан
C. шувтан, зайн, модон D. шувтан, модон, зайн
E. зайн, шувтан, модон

19. Үргэлжлэн холбох нөхцөлтэй хэсгийг олоорой.

- A. Хуурсаар хуурсаар худалч.
B. Нүдийг хужирлаж, сэтгэлийг догдлуулах.
C. Жаргалтай боловч орондоо бүү дуул.
D. Өөх харахлаар зүрх ханах.
E. Үүдээр хөөгдөөд өрхөөр шагайх.

20. “Сайхан газар **аял+сан+аа дурс+чих+аар** ахиад очмоор санагдах юм” өгүүлбэр дэх бүтээврийн нийлцийг зөв бичсэн нь аль вэ?

- A. аяласнаа, дурсчихаар B. аяласнаа, дурсчхаар
C. аялсанаа, дурсчихаар D. аялснаа, дурсчихаар
E. аялснаа, дурсчхаар

21. “Эгшигт гийгүүлэгчийг зөөлрүүлсэн “ь”-ийн дараа заримдаг гийгүүлэгч орвол “ь” хэвээр байна” дүрэмд тохирох үгийг сонгоорой.

- A. тохьгүй B. товъёг C. гавьяа D. авьяас E. хольц

22. Д.Намдагийн “Хөгшин чоно ульсан нь” өгүүллэгийн гол санааг зөв нөхөөрэй.

Чонын амьдралын өшөө хорсол, хайр сэтгэл, баяр гуниг, үржил хорогдол, тэмцэл зэргээр ертөнцийн..... тойрч гажиж болдоггүйг харуулжээ.

- A. ухрах няцах, жам ёсоос B. амьдралын төлөөх, учрал тохиолоос
C. амьд үлдэх, аж амьдралаас D. амьдралын төлөөх, жам ёсноос
E. өл залгуулах, жаргал зовлонгоос

23. Д.Намдагийн “Хөгшин чоно ульсан нь” туужийн “Уг газрын байдал хангай говийн зааг, нам доор газар бөгөөд Дулаан хайрхан хэмээх гурван хэсэг огцом оргилтой уул өмнөө байгаа Тарагтын тал гэгчийг нам тайвнаар ширтэнэ...” хэсэг зохиомжийн аль бүрэлдүүлбэрт хамаарах вэ?

- A. дотоод яриа B. байгалийн зураглал C. харилцан яриа
D. үглэл яриа E. хөрөг дүр



24. Ч.Лодойдамба “Тунгалаг Тамир” романы “Хуяг Олноо өргөгдсөний хоёрдугаар онд Богд Жавзандамба хааны цэрэгт дайчлагдаж, хар цэргийн түрэмгийллийг эсэргүүцсэн өмнө зүгийн тулаанд Хатанбаатар Магсаржавын даргалж байсан цэрэгт явжээ” хэсэгт ямар хам сэдэв дүрслэгдсэн байна вэ?

- А. “цэрэгт дайчлагдах, Хатанбаатар Магсаржав, даргалж явсан” зэрэг үг хэллэгээр илэрсэн тул соёлын
- В. “Олноо өргөгдсөний он, Богд Жавзандамба хаан, Хатанбаатар Магсаржав” зэрэг үг хэллэгээр илэрсэн тул улс төрийн
- С. “хар цэргийн түрэмгийлэл, өмнө зүгийн тулаан, цэрэгт дайчлагдах” зэрэг үг хэллэгээр илэрсэн тул нийгмийн
- Д. “Олноо өргөгдсөний он, Богд Жавзандамба хаан” зэрэг үг хэллэгээр илэрсэн тул шашны
- Е. “Олноо өргөгдсөний он, Богд Жавзандамба хаан, Хатанбаатар Магсаржав” зэрэг үг хэллэгээр илэрсэн тул түүхийн

25. Ч.Лодойдамба “Тунгалаг Тамир” романы “Чи энэ чулуу шиг эдээрээ жинс хийгээд зарвал одоо үед хар ялаа шиг олон болж байгаа ван, бэйл, бэйс, гүнгүүд үнэтэй авах байсан даа” гэсэн Итгэлтийн үгээс дүрийн ямар зан араншин илэрч байна вэ?

- А. оготнын нүхээр багтсан
- В. нойр хоолоо мартсан
- С. нүдээ өгөх шахсан
- Д. дөргүй бух мэт
- Е. амилсан чөтгөр мэт

26. Б.Лхагвасүрэн “Тамгагүй төр” жүжигт:

“Чиний дэргэд

Цаадах чинь нялх

Цадсан болхи шүү дээ, хаантан минь” гэхэд

“...Хүний нүд жавраар хайрсан

Хүүтэй юм байна, чи бид хоёр” гэж хэлдэг. Энэ нь хэн хэний харилцан яриа вэ?

- А. Гүргэл, Арчугийн
- В. Эгэрэг, Цэцэрийн
- С. Цэцэр, Арчугийн
- Д. Эгэрэг, Гүргэлийн
- Е. Гүргэл, Ачирын

27. Б.Лхагвасүрэн “Тамгагүй төр” жүжгийн “Цэцэр ганцаар үлдэн нэлээд хавчиж байснаа, хоёр хүүхдийг сольсноо, тэвчиж чадахгүй дахин буцаана. Тэгснээ дахин сольж, бага хатны хүүхдийг тэврэн авахад хүүхэд нь часхийн уйлна” хэсгээс дүрийн дотоод орчныг тодорхойлно уу.

- А. сандарч мэгдсэн
- В. айж балмагдсан
- С. эргэлзэж тээнэгэлзсэн
- Д. гуниглаж санааширсан
- Е. хулгаж хулчийсан

28. Ц.Чимиддорж “Сэлбэ” шүлгийн

“Газрын хөх судас бүдэг бадагхан цохилно

Гал дундуур урсах мэт бөг бөг шогшино” шад дахь “**бүдэг бадагхан**” хэмээх үгийг өөр үгээр солин найруулбал оновчтой нь аль вэ?

- А. чимээ аниргүйхэн
- В. үл ялигхан
- С. түг түгхэн
- Д. сув сулхан
- Е. нам гүмхэн

29. Ц.Чимиддорж “Сэлбэ” шүлгийн

“Дүүрэн Сэлбэ биднийг ширгэтлээ сэлбэлээ

Дүнжингаравын хамаатан ус цусанд минь аслаа

Аз жаргалын диваажин сууцны чинь паалан хананы

Асуултын тэмдэг шиг цоргоноос нулимс болон дусалж байна” бадгийн холбоцыг тодорхойлоорой.

- А. сөөлжүүлэх холбоц
- В. салаавчлах холбоц
- С. хаших холбоц
- Д. тэгш холбоц
- Е. зэрэгцэх холбоц



30. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж, тодорхойлолтыг гүйцээгээрэй.

Зохиолч тодорхой зорилгоор дүрийн мөн чанарыг илэрхийлэхийн тулд ямар нэг орчин, орон зайг сонгон дүрсэлдэг. Үйл явдал хэзээ, хаана өрнөж байгааг заадаг нь болно.

- A. гадаад орчин В. дотоод орчин С. орчин нөхцөл
D. зохиолын нөхцөл E. зохиолын зохиомж

31.

مصدقہٴ حوالہ
مصدقہٴ شہادت ::

ਅੰਤਰਿਮਾਨੁ ..
ਅੰਤਰਿਮਾਨੁ
ਨਿ ਰਾਜਾ ਮਾਨਸਿੰਹਾ
ਭਾਗੁ ਮਾਨਸਿੰਹਾ

- A. 1972 онд улсын хилийг газар дээр нь тогтоон тэмдэглэсэн.
B. 1962 онд улсын хилийг газар дээр нь тогтоон тэмдэглэсэн.
C. 1962 онд улсын хилийг газар дээр нь тогтон тэмдэглэсэн.
D. 1972 онд улсын хилээ газар дээр нь тогтон тэмдэглэсэн.
E. 1962 онд улсын хилээ газар дээр нь тогтоон тэмдэглэсэн.

32.

بصورت نخستین ..
بصورت دومین ..

- | A. | B. | C. | D. | E. |
|------------|------------|-------------|------------|------------|
| уран санаа | оюун ухаан | оюун сэтгэл | уран ухаан | оюун санаа |

33.

۱۰۰
 ۱۰۰
 ۱۰۰
 ۱۰۰

A.

B.

C.

D. 

Е. Мухоморов

34.

[illegible]

A.

B.

C.

D.

E.

తెలుగు
నామము

സ്മരക
പുസ്തകം

சென்னை

Answer :

Q. Answer.

35.

..

A.

B.

C.

D.

E.

Verfahren

Conjunctive

Wittgenstein

$$\frac{10007607}{7}$$

ሃይማኖት



36.

<<deadX- >>
 үсгүүд нь үсэг
 үсгүүд нь үсэг
 үсгүүд нь үсэг

A. үсгүүд

B. үсгүүд

C. үсгүүд

D. үсгүүд

E. үсгүүд

37.

үсгүүд нь
 үсгүүд нь
 үсгүүд нь
 үсгүүд нь

A. үсгүүд

B. үсгүүд

C. үсгүүд

D. үсгүүд

E. үсгүүд

38.

үсгүүд нь
 үсгүүд нь
 үсгүүд нь

A.

B.

C.

D.

E.

үсгүүд нь үсгүүд нь үсгүүд нь
 үсгүүд нь үсгүүд нь үсгүүд нь
 үсгүүд нь үсгүүд нь үсгүүд нь

үсгүүд нь үсгүүд нь үсгүүд нь
 үсгүүд нь үсгүүд нь үсгүүд нь
 үсгүүд нь үсгүүд нь үсгүүд нь

үсгүүд нь үсгүүд нь үсгүүд нь
 үсгүүд нь үсгүүд нь үсгүүд нь
 үсгүүд нь үсгүүд нь үсгүүд нь

үсгүүд нь үсгүүд нь үсгүүд нь
 үсгүүд нь үсгүүд нь үсгүүд нь
 үсгүүд нь үсгүүд нь үсгүүд нь

үсгүүд нь үсгүүд нь үсгүүд нь
 үсгүүд нь үсгүүд нь үсгүүд нь
 үсгүүд нь үсгүүд нь үсгүүд нь

39.

үсгүүд нь үсгүүд нь
 үсгүүд нь үсгүүд нь
 үсгүүд нь үсгүүд нь

a. үсгүүд

b. үсгүүд

c. үсгүүд

1.

2.

3.

гүрээ

хүрээ

гөрөө

A. a3, b2, c1

B. a1, b3, c2

C. a3, b1, c2

D. a2, b1, c3

E. a2, b3, c1

40.

<<амбулатори>>
 үсгүүд нь үсгүүд нь
 үсгүүд нь үсгүүд нь

A. үсгүүд

B. үсгүүд

C. үсгүүд

D. үсгүүд

E. үсгүүд



ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж:

- Энэхүү хэсэг нь 3 даалгавар, нийт 20 оноотой.
- Сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, тохирох хариуг будаарай.
- Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1. Хэлц ба хэлц бус өгүүлбэрийг жишээтэй нь харгалзуулаарай. (a, b, c, d, e, f мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2 дугаарт байгаа нэр томьёо давхцаж болно.)

a. Намрын шар нар дуусаж, зэврүүн салхи үлээн, уулсын оройгоор цас үзэгдэнэ. b. Ядарч яваа цагт нь гараа сунгасан Итгэлтийг уурлуулах хүсэл Долгорт байсангүй. c. Хөдөөгийн айлууд өвөлжөөгөө бараадан, хот суурин газрын айлууд гэрээ дулаалж эхлэв. d. Холын хүнтэй учирч үг солино гэдэг монгол хүний нэг баяр болдог юм. e. Гэхдээ түм түжигнэсэн их хотыг бодвол амар амгалан, нам гүмийн орон гэсэн үг. f. Би эмэг эхийн гар дээр борви тэнийсэн бөгөөд сургуулийн босго алхталаа өврөөс нь гараагүй.	1. Хэлц өгүүлбэр 2. Хэлц бус өгүүлбэр
---	---

2.2. Ч.Лодойдамба “Тунгалаг Тамир” романы дүрийг, хэлсэн үг хэллэгтэй нь зөв харгалзуулаарай. (a, b, c, d, e, f, g, h мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3 дугаарт байгаа дүр давхцаж болно.)

a. - Надад морь хэрэггүй. Би ариун цагаан хөдөлмөрөөр амьдарна. b. - Монгол хүн гэж ярихын тул монголын төлөө цохилох зүрхтэй байх хэрэгтэй. c. - Би ч эр хүн. Та ч эр хүн. Зодсон ч хэлэхгүй. Бүгдийг аваад ирнэ. d. - Монголын тусгаар тогтнолын төлөө биеэ хайрлахгүй зүтгэх тангаргийг би өгсөн хүн. e. - Одоо би таны гинжинд байгаа болохоор надтай уулзах нь юун завшаан байх билээ. f. - Чи муу хөнгөл дөө. Би ёо гэхгүй. Ах минь намайг бодоорой. g. - Явуулын хүний ганцыг авсныг бодоход дүү минь ядарч дээ. h. - Чи ноёдын сүргээс авдаг гэж байна. Гэтэл над шиг ядарсан хэчнээн амьтныг явгалсан бол доо.	1. Хатанбаатар Магсаржавын үг 2. Хонгорын үг 3. Эрдэнийн үг
---	--

2.3. Үгсийг дүрсээр ялган, утгатай нь зөв тохируулаарай. (a, b, c, d, e, f мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3, 4 дугаарт байгаа үгс давхцаж болно.)

a. хор (атаа)	1.	2.	3.	4.
b. хор- (үйл үг)	ᠬᠣᠷ	ᠬᠣᠷ	ᠬᠣᠷ	ᠬᠣᠷ
c. хор (хөнөөл)				
d. хор (бодис)				
e. хор (чимээ)				
f. хур (тарга)				

